

КАРТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ:

Харилцагч та картынхаа нууцлалыг хамгаалах үүднээс картаа ашиглахдаа дараах зүйлсийг анхаарахыг зөвлөж байна:

- Картын дугаар, хүчинтэй хугацаа, CVV дугаар (харуулах), ПИН кодоо бусдад дамжуулахгүй байх;
- Картын ПИН кодоо өөрийн төрсөн огноо, утасны дугаар гэх мэт өөрийн мэдээлэл бүхий тоогоор сонгохгүй байх;
- Банкнаас ямар ч тохиолдолд харилцагч руу холбогдож ПИН код лавлахгүй гэдгийг анхаарна уу;
- Таны бүртгэлийн мэдээлэл (Гар утас, и-мэйл хаяг, оршин суугаа хаяг) өөрчлөгдсөн тохиолдолд өөрт ойр салбар, нэгжид хандан мэдээллээ шинэчилж хэвших. Энэ нь таныг картын гүйлгээний эрсдэлээс хамгаалахад маш чухал юм;
- Харилцагч та картаа гэсэн, хулгайд алдсан, картын мэдээллээ алдсан тохиолдолд нэн даруй банкинд мэдэгдэж картаа хаалгана уу. Утас: [+976-1800-1917](tel:+976-1800-1917), И-Мэйл: callcenter@khanbank.com.